

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны ... дугаар
сарын . . .-ны өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах журмыг нэгдүгээр, улсын байцаагчийн үнэмлэхийн загварыг хоёрдугаар, улсын байцаагчийн тэмдгийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Л.Мөнхзул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/27 дугаар тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн, 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/140 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

САЙД

Х.БУЛГАНТУЯА

Танилцсан:

Төрийн нарийн бичгийн дарга

Э.Ганхүү

Хянасан:

Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга

Б.Батжаргал

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Д.Ренчиндорж

Боловсруулсан:

Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

Ө.Бодьгэрэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
А/..... дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХИЙГ ОЛГОХ, БАТАЛГААЖУУЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар (цаашид "нийгмийн даатгалын байгууллага" гэх)-ын ажилтанд нийгмийн даатгалын улсын байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх), нийгмийн даатгалын улсын ахлах байцаагч (цаашид "ахлах байцаагч" гэх)-ийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Энэхүү журамд Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль, тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах

2.1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.6-д заасан шалгалтад тэнцсэн ажилтанд улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрх олгоно.

2.2.Энэ журмын 2.1-д заасан шалгалтад тэнцсэн байцаагчийн улсын байцаагчийн болон улсын ахлах байцаагчийн эрхийг баталгаажуулна.

2.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.1-д заасан шалгалтад тэнцсэн ажилтанд нийгмийн даатгалын улсын байцаагч, улсын ахлах байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.4-т зааснаар шийдвэрлүүлнэ.

Гурав. Улсын байцаагчийн эрх түдгэлзүүлэх, цуцлах

3.1.Дараах тохиолдолд байцаагчийн улсын болон ахлах байцаагчийн эрхийг түдгэлзүүлнэ. Үүнд:

3.1.1.хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацаанд;

3.1.2.нийгмийн даатгалын байгууллага хооронд, эсхүл байгууллага дотроо албан тушаалын тодорхойлолтод зааснаар улсын байцаагч, улсын ахлах байцаагч байх шаардлагагүй албан тушаалд сэлгэн болон шилжин ажиллаж байх хугацаанд;

3.1.3.гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлангийн үнэлгээгээр

“Хангалтгүй” дүгнүүлсэн бол дараагийн “Маш сайн, Хэвийн” үнэлгээ авах хүртэл хугацаанд (эсвэл энэ хугацаанаас өмнө улсын байцаагчийн эрхийг олгох шалгалт авах бол шалгалтад орж тэнцэх хүртэл хугацаа).

3.2.Энэ журмын 3.1-д заасан хугацаа дуусаж, албан тушаалын тодорхойлолтод зааснаар улсын байцаагч, улсын ахлах байцаагч байх шаардлагатай албан тушаалд томилогдсон ажилтанд улсын болон ахлах байцаагчийн эрхийг сэргээн олгоно.

3.3.Дараах тохиолдолд байцаагчийн улсын болон ахлах байцаагчийн эрхийг цуцална. Үүнд:

3.3.1.Төрийн албаны тухай хууль, нийгмийн даатгалын хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчсөн;

3.3.2.төрийн захиргааны албан хаагчийн болон Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д заасан байцаагчийн эрх үүрэг, хориглох зүйл, ажилтны ёс зүйн хэм хэмжээг ноцтой буюу удаа дараа зөрчсөн, эсхүл мэргэжлийн алдаа гаргасан;

3.3.3.албан тушаалын тодорхойлолтод заасан албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн, хуулиар олгосон улсын байцаагчийн эрхийг хэтрүүлсэн;

3.3.4.торгууль шийтгэлийн төлбөр болон маягт, үнэт цаас, ажил үйлчилгээний хураамжийн орлогыг хувьдаа завшсан нь дотоодын хяналт болон холбогдох хууль, хяналтын байгууллагаар тогтоогдсон;

3.3.5.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

3.2.6.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.6-д заасан шалгалтад ороогүй тохиолдолд дараагийн шалгалтад тэнцэх хүртэл хугацаанд;

3.3.7.ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан;

3.3.8.тэтгэвэрт гарсан, өөр байгууллагад шилжин ажилласан;

3.3.9.нас барсан.

3.4.Энэ журмын 3.1-3.3-т заасан шалтгаанаар улсын болон ахлах байцаагчийн эрх түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах тухай саналыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавьж шийдвэрлүүлнэ.

3.5.Энэ журмын 3.1, 3.3-т заасны дагуу улсын болон ахлах байцаагчийн эрх түдгэлзүүлсэн, эрх цуцлагдсан ажилтны хэрэглэж байсан үнэмлэх, тэмдгийг харьяалах газар болон аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын дарга акт үйлдэн хураан авч, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Тамгын газрын дотоод ажил хариуцсан ажилтанд хүлээлгэн өгнө.

3.6.Улсын болон ахлах байцаагчийн эрх нь түдгэлзсэн, цуцлагдсан ажилтны үнэмлэх, тэмдэг, акт, албан шаардлагын маягт, торгууль шийтгэлийн хуудсыг хурааж аваагүй, тушаагаагүй тохиолдолд тухайн газрын даргаар үнэмлэх, тэмдэг,

маягт, үнэт цаасны үнийг гурав дахин нэмэгдүүлэн төлүүлж, хүчингүй болгуулах арга хэмжээ авна.

---oOo---

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
А/..... дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН БОЛОН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮНЭМЛЭХИЙН ЗАГВАР

Үнэмлэхийн хавтасны загвар



Улсын ахлах байцаагчийн
үнэмлэхийн загвар

Улсын байцаагчийн
үнэмлэхийн загвар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Дугаар: _____

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Овог: _____
Surname: _____
Нэр: _____
Name: _____

Дугаар: _____

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн арга хэмжээ авч, хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан тул нийгмийн даатгалын Улсын байцаагчийн эрх (үнэмлэх) олгов.

The National Inspector license provides the Officer with assessments and oversight of Social Insurance regulatory compliances, operations and processes through investigations, inspections and imposing liability to regulation violation.

Олгосон / Issued: _____

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Үнэмлэхийг зориулалтын бусаар ашиглах,
бусдад шилжүүлэхийг хориглоно

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

Дугаар: _____

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Овог: _____
Surname: _____
Нэр: _____
Name: _____

Дугаар: _____

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн арга хэмжээ авч, хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан тул нийгмийн даатгалын Улсын байцаагчийн эрх (үнэмлэх) олгов.

The National Inspector license provides the Officer with assessments and oversight of Social Insurance regulatory compliances, operations and processes through investigations, inspections and imposing liability to regulation violation.

Олгосон / Issued: _____

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Үнэмлэхийг зориулалтын бусаар ашиглах,
бусдад шилжүүлэхийг хориглоно


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
А/..... дугаар тушаалын гуравдугаар
хавсралт

**УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН БОЛОН УЛСЫН
БАЙЦААГЧИЙН ТЭМДГИЙН ЗАГВАР**

Улсын ахлах байцаагчийн
тэмдгийн загвар



Улсын байцаагчийн
тэмдгийн загвар



---oOo---

Журам батлах хууль эрх зүйн үндэслэл:

Одоогийн мөрдөж буй хууль:

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана”

Нийгмийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“Нийгмийн даатгалын байгууллагад 2-оос доошгүй жил ажиллаж мэргэшсэн, мэргэжлийн өндөр зэрэгтэй нийгмийн даатгалын байгууллагын ажилтанд нийгмийн даатгалын төв байгууллагын саналыг үндэслэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр нийгмийн даатгалын байцаагчийн эрх олгоно. Нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийг Засгийн газар батална”

Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм” /Хавсаргав./

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/27 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам" /Хавсаргав./

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх шинэ хууль:

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д:

“Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам, улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн загварыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”